



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.04.18 № 01/324  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БАЯНЗҮРХ  
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН 2023 ОНЫ НӨХӨН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БАЯНЗҮРХ  
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНД

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох Баянзүрх сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

#### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

#### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

#### Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох Баянзүрх сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3

дахь хэсэг, "Алсын хараа-2050" болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр /.../ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Сонгуулийн хороонд  
Хавсралт /.../ хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛӨХ  
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР


Б.ТЭГШДЭЛГЭР

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

З.ДАВААДОРЖ






**БАЯНЗҮРХ СУМЫН ИТХ-ЫН 2023 ОНЫ  
НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ  
АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

*Б. Могой* 3.2023

**Агуулга:**

- Мөрийн хөтөлбөрийн үндэслэл .....**
- 1. Хүний хөгжлийн бодлого .....**
  - 1.1 Орлоготой иргэн.....**
  - 1.2 Эрүүл иргэн .....**
  - 1.3 Чанартай боловсрол.....**
  - 1.4 Аз жаргалтай гэр бүл .....**
  - 1.5 Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр.....**
  - 1.6 Залуучуудыг дэмжих чиглэлээр .....**
  - 1.7 Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийг дэмжих чиглэлээр .....**
  - 1.8 Ахмадуудад үзүүлэх үйлчилгээний чиглэлээр .....**
  - 1.9 Үндэсний бахархал, өв соёл, спорт .....**
- 2. Эдийн засгийн бодлого .....**
  - 2.1 Мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл .....**
  - 2.2 Аялал жуулчлал .....**
  - 2.3 Төсөв санхүү .....**
- 3. Ногоон хөгжлийн бодлого .....**
- 4. Сумын төвийн тохижилт дэд бүтцийн хөгжилийн бодлого .....**
- 5. Засаглалын бодлого .....**



Handwritten signature and date: 3.2.23

Сумын МАН-ын хорооны  
Тэргүүлэгчдийн 2023 оны  
02 дугаар тогтоолын хавсралт

## 2023 ОНЫ СУМЫН ИТХ-ЫН НӨХӨН СОНГУУЛЬД МАН-ААС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР


### Мөрийн хөтөлбөрийн үндэслэл :

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Алсын хараа – 2050 урт хугацааны хөтөлбөр, бодлого
- “Хөгжсөн Хөвсгөл -2030” хөтөлбөр
- 2020 оны УИХ-ын сонгуульд МАН-аас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр
- “Хүчээ нэгтгэе ” аянд иргэдийн ирүүлсэн санал

### НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

#### 1.1 Орлоготой иргэн

- 1.1.1. Иргэдийн орлогыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах зорилгоор ажлын байр шинээр бий болгож байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 1.1.2. Бага, дунд орлоготой иргэдийг төрийн бодлогоор дэмжиж, иргэдэд бага хүүтэй зээл, хөтөлбөрт хамруулана.
- 1.1.3. Өрхийн бичил бизнесийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ
- 1.1.4. Гарааны бизнес эрхлэгч оюутан, залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.1.5. Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.1.6. Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.1.7. Сум багийн хүн амын хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.8 Иргэдийн туршлага, ур чадвартаа түшиглэн хувиараа хөдөлмөр эрхлэх боломж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээл авахад нь бүх талаар дэмжиж ажиллана.



Handwritten signature and date: 3.28.23

## 1.2 Эрүүл иргэн

1.2.1 Хүүхэд, ялангуяа нялхсын эндэгдлийг тууштай бууруулж, **“Хүүхдэд ээлтэй сум болох”** зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

1.2.2 **“Эмийн зохистой хэрэглээ”** аяныг зохион байгуулж, **“Зөв тун”** эмийн сангийн чадавхыг бэхжүүлж, нэн зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг 100%-д хүргэнэ.

1.2.3 Иргэн бүр эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр заавал хамрагдах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.2.4 **“Элэг бүтэн Монгол”** хөтөлбөрийг үргэлжлүүлж, **“Хавдрын эсрэг хамтдаа”** хөтөлбөр орон нутагт хэрэгжүүлнэ.

1.2.5 **“Эрүүл шүд-Эрүүл хүүхэд”** хөтөлбөрийг сумандаа хэрэгжүүлж, хүүхдийн хоолойн архаг (ангина) өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх **“Эрүүл ирээдүй”** хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.6 **“Эрүүл чийрэг эр хүн”** хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлж дундаж наслалтыг уртасгана.

1.2.7 Эмэгтэйчүүдийн товлोलт дархлаажуулалтыг сум, багийн хэмжээнд нэвтрүүлж, умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, хөхний эрүүл мэндийг хамгаалах **“Гэр бүл төлөвлөлтийн”** хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

1.2.8 Яаралтай тусламжийн сүлжээний чадавхыг дээшлүүлж, сумын эрүүл мэндийн төв, багийн эмчийн түргэн тусламжийн автомашин, мотоциклын парк шинэчлэлт хийх ажлыг холбогдох шатанд уламжилж шийдвэрлүүлнэ.

1.2.9 Эмнэлгийн ажиллагсдын нийгмийн асуудал, ажиллах орчинг сайжруулан, сумын эрүүл мэндийн төвийг ажилтан, мэргэжилтнээр бүрэн хангана.

1.2.10 Сумын эрүүл мэндийн төвийг халуун, хүйтэн ус, ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг шийдвэрлүүлнэ.

1.2.11 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах **“Цахим карт”** олгож хэрэгжүүлж ажиллана.

1.2.12 Иргэдэд эрүүл мэндийн бүх талын боловсролыг ЕБС-д суралцаж байх үеэс олгож, эрүүл мэндийн **“анхны тусламж”** үзүүлэх чадавхыг хүн бүрд эзэмшүүлнэ.


1.2.13 Сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, эхчүүдийн амрах байрыг холбогдох дээд шатны байгууллагуудад уламжлан улсын төсвийн хөрөнгө оруулалтанд тусгуулан ашиглалтанд оруулна.

## 1.3 Чанартай боловсрол

1.3.1 Дотуур байрыг хүүхдийн сурах, хөгжих, эрүүл аюулгүй ээлтэй орчин болгон, хүчин чадлыг бүрэн ашиглаж, 6 настай хүүхдийн амьдрах сурах нөхцөлийг сайжруулна.

1.3.2 Сургуулийн номын санг **“Цахим номын сан”** болгож, утасгүй интернэтийн орчныг нэмэгдүүлнэ.

1.3.3 Аймгийнхаа **“Оюунлаг- Хөвсгөл”** хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

 3.2023

1.3.4 Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаанд хамруулж, “Чадварлаг багш” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

1.3.5 Цэцэрлэгийн бүлэг бүрд 2 ээлжийн бүлгийн багш ажиллуулан хүүхэд хүлээж авах, өгөх цагийг уртасгаж эцэг, эхчүүдэд ажлаа тараад хүүхдээ авдаг боломжийг бүрдүүлнэ.

1.3.6 ЕБС-д үдийн хоол хөтөлбөрийн хүрээнд хүүхдэд шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчилэхэд хяналт тавьж ажиллана.

1.3.7 Хичээлээс гадуурх сургалтын үндэсний хөтөлбөрийн дагуу сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг нэмэгдүүлж, орлцоо үр дүнг дэмжинэ.

1.3.8 Нүхэн жорлонгийн ашиглалтыг зогсоож, цэцэрлэг, сургууль, дотуур байрны ариун цэврийн өрөөний чанар үр ашгийг нэмэгдүүлэн, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

1.3.9 Улс, аймаг, сумын түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож, амжилт үзүүлсэн суралцагч, багш, баг хамт олон, массын сургалтаар манлайлагч багшийг дэмжин урамшуулах тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлнэ.

1.3.10 Сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлж тогтворжуулна.

1.3.11 Мэдээллийн технологи, дизайн технологи, биеийн тамир спорт, эрүүл мэнд, хөгжим урлагийн хичээлүүдийн материаллаг баазыг шинэчлэн хөгжүүлнэ.

#### 1.4 Аз жаргалтай гэр бүл

1.4.1 Жирэмсэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд онцгой анхаарч, ургийн эрт үеийн оношилгоонд, жирэмсний хяналтад бүрэн авч, сургалт арга зүйгээр хангана.

1.4.2 Эмэгтэйчүүдийн үүсгэл санаачилгын клуб, холбоо, нөхөрлөл ТББ-дыг бодлогоор дэмжин хамтран ажиллана.

1.4.3 Эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

1.4.4 Ганц бие, өрх толгойлсон эмэгтэйчүүдийг үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэхэд дэмжинэ.

1.4.5 Баялаг бүтээгчдийг төрийн бодлогоор дэмжинэ.

1.4.6 Орон нутгийн төрийн байгууллагаас үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдийн хөдөлмөрийг үнэлэн, тэднийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.

1.4.7 Төрийн худалдан авалтад сумынхаа баялаг бүтээгч, үйлдвэрлэгчдээ давуу эрх олгох, зарчим баримтална.

1.4.8 Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг үндэслэн, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.

1.4.9 Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

1.4.10 Хүн бүр угийн бичгээ хөтлөх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, удмын сангаа хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.4.11 Их, дээд сургууль төгссөн залуучуудаа сумандаа эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөх, бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж, цахим мэдээллийн систем, хөдөлмөрийн мэдээллийн санг бий болгоно.

1.4.12 Өрхийн аж ахуй эрхлэх үүсгэл, санаачилгыг дэмжиж, төсөл хөтөлбөрт хамруулж, амьжиргааг нь дээшлүүлнэ.

### **1.5 Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр**

1.5.1 Хүүхдийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, вакцинд тогтмол хамруулж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.5.2 Нүүдлийн болон зуны цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, үргэлжлэх хугацааг уртасгаж, цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

1.5.3 “Хүүхдийн амьдрах, сурах, хамгаалагдах, хөгжлийг дэмжих чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрүүдийг нэмэгдүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг нэмэгдүүлж хүүхдийн төлөө зарцуулна.

1.5.4 6-15 насны хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, хүндэтгэн үзэх шалтгаангүй сургууль завсардалтгүй болгоно.

1.5.5 Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшлийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.5.6 Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.

1.5.7 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.

### **1.6 Залуучуудыг дэмжих чиглэлээр**

1.6.1 Эрэлттэй ажлын байрны судалгаа гаргаж, мэргэжилтэй ажилтан бэлтгэх талаар аймгийн МСҮТ-тэй хамтран сумандаа дунд, богино хугацааны сургалтуудыг зохион байгуулж, залуучуудыг хамруулна.

1.6.2 Гэр бүл, хүүхэд, оюутан, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин нөхцлийг сайжируулна.

1.6.3 Хүүхэд, оюутан, залуучууд, өсвөр үеийнхнийг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

1.6.4 Залуу гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн "Залуу гэр бүл" хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

### **1.7 Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийг дэмжих чиглэлээр**

 3.2023



1.7.1 Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, хамрагдах иргэдийг бүрэн хамруулж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

1.7.2 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд зорилтот бүлгийн өрхийг нэн тэргүүнд хамруулж, өрхийн орлогыг нь нэмэгдүүлнэ.

1.7.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжүүлэх, хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

1.7.4 Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэд хэрэгцээт үйлчилгээгээ авах нөхцөлийг төрийн болон бусад бүх байгууллагад бүрдүүлнэ.

## 1.8 Ахмадуудад үзүүлэх үйлчилгээний чиглэлээр

1.8.1 Ахмадын зөвлөх үйлчилгээг бий болгож, хүүхэд залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадварыг өвлүүлнэ.

1.8.2 Ахмадын талаарх төрийн бодлого, хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, ахмадуудыг бүрэн хамруулж ажиллана.

1.8.5 Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлж, ахмадын өргөөг шинээр барих ажлыг шийдвэрлүүлнэ.

1.8.6 Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх ажил эрхлэлт, зөвлөх үйлчилгээг үр дүнтэй хэлбэрээр үргэлжлүүлнэ.

## 1.9 Үндэсний бахархал, өв соёл, спорт

1.9.1 Соёлын төвийн барилга байгууламж, орчин нөхцөл, техник хэрэгсэл, материаллаг баазыг бэхжүүлэхэд анхаарч, иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмж, давтамжийг нэмэгдүүлнэ.

1.9.2 Орон нутагт тэргүүлэх чиглэлийн болон үндэсний спортын төрлүүдийг түлхүү хөгжүүлж, нийтийг хамарсан спортын арга хэмжээг өргөжүүлнэ.

1.9.3 Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, Монгол бичгийн олимпиадыг иргэдийн дунд уламжлал болгон явуулна.

1.9.4 Хөдөөгийн багуудын “Мэдээллийн төв”-үүдийг засварлан тохижуулж, биеийн тамирын задгай талбайг баг бүрд засварлан тохижуулах ажлыг зохион байгуулна.

1.9.5 Орон нутагт Монголынхоо нүүдлийн соёл иргэншил, үнэт зүйлийг танилцуулсан өв, соёл, урлаг, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.9.6 Түүх, соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай тэмцэж, хариуцлагыг чангатгаж, биет болон биет бус өвийг хамгаална.


1.9.7 Биеийн тамир, спортын арга зүйчийг чадвахчуулан ажлын байрыг тохижуулж үйл ажиллагааг өргөжүүлэн чанаржуулна.

1.9.8 Биеийн тамир, спортод хөрөнгө оруулалт хийсэн хувь хүн, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

### 2.1 Мал аж ахуй, газар тариалан үйлдвэрлэл

2.1.1 ХАА-н үйлдвэрлэлийг эрчимжүүлэх бодлого баримтална.



2.1.2 “Монгол мал-2” хөтөлбөрийг сумандаа хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлэн, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулна.

2.1.3 Хууль ёсны эрх бүхий мэргэжлийн байгууллагаар малд үзлэг ангилалт хянан баталгаажуулалтын ажлыг хийлгэж, Дархад үүлдрийн хониор сумын цөм сүрэг бүрдүүлэх, мөн ноолуурын чиглэлийн “Эрчмийн хар” үүлдрийн ямааны хээлтүүлэгчээр сүрэг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.

2.1.4 Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, малын эмч, мал зүйч мэргэжилтэн бэлтгэх, сумын мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн мэргэжлийн аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллана.

2.1.5 Хувийн хэвшлийн мал эмнэлгүүдийг бэхжүүлж, мал амьтны гаралтай өвчний голомтыг устгах, ариутгал, халдваргүйжүүлэх, ажлын чанар үр дүнг дээшлүүлж, мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулна.

2.1.6 Малчдын зөвлөгөөн болон шилмэл малын үзэсгэлэн худалдааг жилд 1, 1 удаа тогтмол зохион байгуулна.

2.1.7 Мал, амьтны гаралтай түүхий эд /Арьс шир, үс, ноос ноолуур, эсгий эдлэл, мөн дайвар бүтээгдэхүүн / боловсруулах жижиг цех, үйлдвэрийг бодлогоор дэмжинэ.

2.1.8 Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, малын гаралтай бүтээгдэхүүний цахим тогтолцоог хөгжүүлнэ.

2.1.9 Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжиж, дотоодын сүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг өсгөж, сүүгээ борлуулж буй малчдад зориулсан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

2.1.10 Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллана.

2.1.11 Тэжээлийн олон наст ургамлыг нутагшуулж, тариалах ажлыг зохион байгуулж ажиллана.

2.1.12 Малын тэжээлийн үйлдвэр, цех байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлж, сумын өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.1.13 ХАА-н даатгалын тогтолцоог нэмэгдүүлж, малчин, тариаланчдыг эрсдэлээс хамгаална.

## 2.2 Аялал жуулчлал

2.2.1 Аялал жуулчлалыг сумын эдийн засгийн туслах салбарын нэг болгон хөгжүүлэх тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ.

2.2.2 Дотоодын амрагч, аялагчдад зориулсан амралт зугаалгын бүсчлэлийг тогтоож, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал, гар урлалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

2.2.3 Байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдийг түшиглэсэн тогтвортой эко аялал жуулчлалыг сумандаа хөгжүүлнэ.

2.2.4 Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуу чиглэлд жуулчны отог байгуулахаар зөвшөөрөл авсан иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг эхлүүлэн, тогтмолжуулна.



## 2.3 Төсөв санхүү

2.3.1 Төсөв санхүүгийн шинэчлэлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, санхүүгийн албаны ажилтнуудын чадавхыг дээшлүүлнэ.

2.4.2 Төр, хувийн хэвшлийн статистик мэдээллийн санг бүрдүүлж, хүн ам, ерхийн мэдээллийн сангийн баяжилт, тооцооллыг сайжруулна.

2.4.3 Төсвийн үр ашиггүй зардлыг танаж, хэмнэлтийн горимд шилжүүлж, төсвийг үр дүнтэй зарцуулна.

2.4.4 Татвар хураалтыг цахимжуулах ажлыг хэрэгжүүлж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлнэ.

2.4.5 Санхүүгийн ажилтнуудын компьютер, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх чиглэл баримтлан ажиллана.

2.4.5 Шинээр ажлын байр нэмэгдүүлсэн иргэд, аж ахуйн нэгжийг татварын хөнгөлөлт, урамшууллын бодлогод хамруулна.

## ГУРАВ . НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1 Ойн хөнөөлт шавжийн тархалт, өсөлт, бууралтыг хяналтад авч, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.

3.2 Гол горхи, булаг шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, нутаг дэвсгэрийн рашаануудын химийн найрлагыг тогтоолгоно.

3.3 Цаг агаарын мэдээ, мэдээллийг цахим хэрэгслээр олон нийтэд хүргэх, түгээх, ажлын чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

3.4 Газар зүйн мэдээллийн системд суурилсан “Ухаалаг, цахим газрын зураг” үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж, газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгоно.

3.5 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлнэ.

3.6 Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх бодлого баримтлана.

3.7 “Ногоон хэрэм” төсөл хэрэгжүүлж, дэд бүтцийн байгууламж, бэлчээр ашиглалтын улмаас эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж дахин ашиглах боломжтой болгоно.

3.8 Сумын төвийн ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг 25 хувьд хүргэнэ.


3.9 Бэлчээрийг усжуулах бодлого баримтлан, малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.

3.10 Бэлчээрийг нөхөн сэргээх “Малчдын дундын сан”-г бий болгоно.

3.11 Түймэрт өртсөн, хортонд идэгдсэн, тахилга шүтээнт уул толгодын орчинг ойжуулах арга хэмжээг иргэд, ойн нөхөрлөлүүд төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

## ДӨРӨВ. СУМЫН ТӨВИЙН ТОХИЖИЛТ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО


4.1 Сумын төвд иргэдийн амарч тухлах, чөлөөт цагаа өнгөрөөх ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулна.



- 4.2 Ногоон байгууламжийг бий болгосон иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулж, айл өрхийн ногоон стандартыг бий болгож мөрдүүлнэ.
- 4.3 Хог хаягдлыг байгальд халгүй аргаар устгах технологи, менежментийг судлан хэрэгжүүлж эхлэнэ.
- 4.4 Сумын төвд ахуйн үйлчилгээний төвийг бий болгоход анхаарч, иргэд халуун ус, үсчин, гоо сайхан, хими цэвэрлэгээний үйлчилгээг тогтмол авах боломжтой болгоно.
- 4.5 Газар хөдлөлт, байгалийн гамшгийн эрсдэл аюулыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд барилга, байгууламж, орон сууцыг бүртгэлжүүлэнэ.
- 4.6 Сумын төвийн иргэдийн аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлж, авто зам, гудамж, олон нийтийн зам талбайг гэрэлтүүлэх камержуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 4.7 Сумын төвийн айл, өрх, албан газруудыг халаалтын нэгдсэн системд холбох талаар арга хэмжээ авч ажиллана.
- 4.8 Гудамж, байшин барилгын хаягийн нэгдсэн стандартыг нэвтрүүлнэ.
- 4.9 Өрхүүдийг бохирын байгууламж байгуулах, био жорлон нэвтрүүлэх замаар нүхэн жорлонгоос татгалзаж хөрсний бохирдлыг багасгана.
- 4.10 Зорчигч тээврийн олон төрөлт үйлчилгээ бий болгож, иргэдийг богино хугацаанд зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.11 Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд орон нутгийн нийтлэг шаардлагад нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулж, газар зохион байгуулалтын төлөвлөлтийг боловсронгуй болгон мөрдөнө.
- 4.12 Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагыг инженерийн шугам сүлжээ бүхий тохилог орон сууц, эдэлбэр газар, амины орон сууцтай болох нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- 4.13 Орон нутгийн чанартай зам, давааг засаж сайжруулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулна.
- 4.14 Сумын нутаг дэвсгэр дахь гол, мөрний дагавар гүүрнүүдийг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллана.
- 4.15 Сумын төвийн доторх замуудыг сайжруулж бетонон 2-4 км замыг шинээр тавих ажлыг шийдвэрлүүлнэ.


## ТАВ . ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 5.1 Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны давхардлыг арилгах, орон тоо бүр дээр мэргэжлийн албан хаагчдыг бүрэн ажиллуулна.
- 5.2 Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, “Сумын хэмнэлтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.
- 5.3 Төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг “Нэг иргэн- Нэг бүртгэл” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 5.4 Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлж, хүнд суртал, үүсгэж буй үйлчилгээнүүдийг цахимжуулна. ( цахим татвар, цахим иргэний бүртгэл, цахим газрын харилцаа, цахим эрүүл мэнд, цахим боловсрол гэх мэт)



Б. Мунгуу 3.28г

- 5.5 Хүнд сурталгүй төрийн үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхжуулж, төсвийн зардлыг хэмнэнэ.
- 5.6 Төрийн бодлого, захирамж, хөтөлбөр, журам боловсруулан, шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих зорилготойгоор цахимаар оролцох боломжийг бий болгоно.
- 5.7 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг болно.
- 5.8 Газарзүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлнэ.
- 5.9 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.
- 5.10 Төр, иргэний нийгэм болон бизнесийн байгууллагад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хандлага төлөвшүүлж, авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх мэдээллийг урамшуулах эдийн засгийн болон бусад хөшүүргийг бий болгоно.
- 5.11 Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.
- 5.12 Төрийн албанд шинээр томилогдсон иргэнийг орон нутаг, төрийн албаны анхан шатны нэгжид ажиллуулан дадлагажуулах замаар мэдлэг чадвар, туршлагыг нэмэгдүүлнэ.
- 5.13 Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, хандлагыг эрс шинэчилнэ.
- 5.14 Сумын төвийн гудамж талбайд гэрэлтүүлэг хийх, камержуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр үр дүнд хүрнэ.
- 5.15 Хүн амын хүнсний болон эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах зорилгоор гарч буй зөрчил дутагдлыг арилгах, хяналт тавих үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 5.16 Гамшигт үзэгдлүүд (ган зуд, хүчтэй шороон шуурга г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг тогтмол явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 5.17 Хэрэглэгчийн эрхийг хамгаалах салбар зөвлөлийн үйл ажиллагааг эхлүүлнэ.
- 5.18 Олон нийтийг хамарсан халдварт өвчин, цар тахал, байгалийн гамшиг зэрэг аюулыг эрсдэлгүй даван туулахад бэлдэж, сумын онцгой комисс, шуурхай штабын үйл ажиллагааг чадавхижуулана.
- 5.19 Сумын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээлэл технологийн ололтыг нэвтрүүлж, төрийн албаны архивын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, "Цахим архив"-ын баяжилтыг нэмэгдүүлнэ.
- 5.20 "Иргэний танхим"-ыг техник тоног төхөөрөмжөөр хангаж, иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгөх, мэдээлэл сурталчилгааны ажлын чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Handwritten signature and date: 3.28.23

5.21 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог дээшлүүлж, хамтын ажиллагааг сайжруулж, гэмт хэргийн гаралтыг тогтвортой бууруулна.

5.22 Орон нутагт ажиллах багш, эмч, төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэн тогтвор суурьшилтай ажиллуулна.

**Баянзүрх сумын  
Монгол Ардын Намын хороо**



*Handwritten signature and date*  
3.28.23